

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 06 дугаар сарын 01-ээс 12-ны өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 692 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 380 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 312 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн хилийн боомтод 237 гадаадын иргэнд зохих ангиллын, төвд 1 гадаадын иргэнд олон удаагийн Монгол Улсын виз олгосон. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
380	312	238	303	719	0	78	50
692							

06 дугаар сард нийт 175 аж ахуйн нэгж, байгууллагын 475 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

“evisa.mn” цахим системээр нийт 24 улсын 669 иргэнд цахим виз олгож, 1 улсын 1 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 303 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 719 иргэний оршин

суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 198 иргэний бүртгэлд хасалт хийлээ. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 7 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 26 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 78 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 50 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 63,8 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 38,0 хувиар тус тус өсөж, виз олголт 33,3 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 12,4 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 677 ширхэг шинээр хэвлэж, 349 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 9 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 20 иргэний хүсэлтийг шийдвэрлэв.

### 1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 1469 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
1288	100	12	54	15	1469

Визийн зөвшөөрлийн дугаар бүхий имэйлийг 251 иргэн, хуулийн этгээдэд илгээж, 712 гадаадын иргэнд оршин суух үнэмлэх олгосон.

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 47 иргэнд, утсаар 55 иргэнд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн.

## 1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

### 1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар нийт 4 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 11 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг хийлээ. (Хүснэгт 4)

#### Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
06 дугаар сар 2022 он /өссөн дүнгээр/	-	-	-	10
	1	-	-	186

Түүнчлэн 9 иргэн, 2 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 13 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүллээ. (Хүснэгт 4)

#### Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад Улс	-	2	-	-	-
	нийт	-	2	-	-	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	4	-	11	9	13
	нийт	4	-	11	9	13
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	-	2	-
	нийт	-	-	-	2	-

Монгол Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Австри Улсын харьяат болохоор 4 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

Засгийн газрын 2003 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”-ын 2 дахь хэсгийн 2.3.3-т заасан үндэслэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2 иргэний Монгол Улсын харьяат болох хүсэлтэд татгалзсан.

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4080 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 10 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 3)

### 1.2.2. Хүүхэд үрчлэлт:

06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

### 1.2.3. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай 1 байгууллагын хүсэлтийг хүлээн авч, 1 байгууллагад тодорхойлолт олгов.

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай хүсэлт гаргасан олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газруудын хүсэлтийг хэлэлцүүлж, 1 байгууллагын зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунган, 2 байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болголоо.

### 1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

#### 1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1035 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтаар 19 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт шалгалт явуулахад зөрчил илрээгүй байна.

Төлөвлөгөөт бус 11 удаагийн хяналт шалгалтыг 12 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 33 иргэнийг хамруулан зохион байгуулж, паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй.

Хүснэгт 5

Торгуулсан гадаадын иргэн						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-3.2	16.2-3.3		
1	Америк	1			1	100000
2	Вьетнам	1			1	100000
3	Герман	2			2	200000
4	Казахстан		1	3	4	7,500,000
5	Колумб	1			1	100000
6	Орос	1			1	100000
7	Өмнөд Солонгос	3			3	300000
8	Турк	1			1	100000
9	Хятад	1	1		2	2,100000
Нийт		11	2	3	16	10,600,000

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх зорилгоор ажиллуулж буй 70133448 дугаар утсаар дамжуулан ирүүлсэн зөрчлийн шинжтэй 1 гомдол,

мэдээллийг хүлээн авч, 2 аж ахуйн нэгж, 8 иргэний баримт бичигт үзлэг шалгалт явуулахад зөрчил илрээгүй тул гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, зөрчил гаргаснаа сайн дураар илчилсэн 12 иргэнд холбогдох гомдлыг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.

Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн болон оршин суух хугацааг хэтрүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн нийт 9 улсын 16 гадаадын иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу 10,600,000 төгрөг (Арван сая зургаан зуун мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6)

Хүснэгт 6


Зөрчлийн мэдээ (тухайн сард)							
Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
16	10,600,000	-	-	-	-	-	-
нийт 10,600,000 төгрөг							
Зөрчлийн зүйлчлэл							
Хуулийн үндэслэл	Шалтгаан					Гадаадын иргэний тоо	
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн					11	
Зөрчлийн тухай хууль 16.2-3.2	оршин суух хугацааг хэтрүүлсэн					2	
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3	визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно					3	
нийт						16	

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэний Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд хариу тайлбар болон Бүгд Найрамдах Франц Улсын иргэний шаардлагад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хариу тайлбарыг тус тус гаргасан.

### 1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтыг үндэслэн Бүгд Найрамдах Казахстан Улсын 2, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2, нийт 4 гадаадын иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэний тус улсын хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн байна. (График 2)

Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 6 улсын 8 иргэн, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс 1 улсын 1 иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаажээ.



06 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3,1 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 50,0 хувь, саатуулсан гадаадын иргэн 66,7 хувиар тус тус өсөж, албадан гаргасан гадаадын иргэн 5,6 хувь, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 66,7 хувиар тус тус буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Байгууллагын зохион байгуулалтын нэгж хоорондын шуурхай байдлыг хангах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд байгууллагын даргын 06 дугаар сарын 10-ны өдрийн “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” (erp.e-mongolia) ашиглах тухай” А/93 дугаар тушаалыг батлан, хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын даргын 06 дугаар сарын 10-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын эрхэм зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааг нэг өнгө төрх, загвараар илэрхийлж, байгууллагын ялгамж чанарыг таниулах зорилго бүхий “Брэндинг, загвар”-ыг батлан “Хуулийн сан”-д байршууллаа.

Түүнчлэн байгууллагын 06 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 06 дугаар сарын 03-ны өдөр баталж, 05 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг 06 дугаар сарын 10-ны өдөр нийт албан хаагчдад цахим (erp.e-mongolia.mn)-аар танилцуулав.

Байгууллагын 05 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1017 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

#### 2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээний хагас жилийн биелэлтийн үнэлгээг баталгаажуулах “Үнэлгээний баг”-ийг байгууллагын даргын 06 дугаар сарын 09-ний өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулав.

Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоол, Засгийн газрын мөн оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолын дагуу албан тушаалын цалингийн сүлжээний 1-4 дэх шатлалд хамаарах нийт 33 төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалинг байгууллагын даргын 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/155 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баярыг тохиолдуулан 1 албан хаагчийг төрийн дээд одон медаль шагналд нэр дэвшүүлж, холбогдох баримт бичгийг 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1047 дугаар, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Жендэрийн салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1052 дугаар, Хүүхдийн эрх хамгааллын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн салбараас 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/1076 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гадаад харилцааны яамнаас “Дипломат төлөөлөгчийн газруудад ажиллахаар томилогдсон албан хаагчдад зориулсан консулын үйл ажиллагааны асуудал” сэдвээр 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан сургалтад Иргэний харьяаллын газрын мэргэжилтнүүд оролцож иргэний харьяалал болон хүүхэд үрчлэлтийн асуудлаар мэдээлэл хүргэлээ.

#### 2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 5, цахим сүлжээнд 17 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 45 хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. “Гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хасалт, түр ирэгчийн хугацаа сунгуулах хүсэлтүүдийг цахимаар хүлээн авна” мэдээг нийт 21 мэдээллийн сайтаар дамжуулан олон нийтэд хүргэжээ.

#### 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

##### 2.2.1. Хууль, эрх зүй:

Байгууллагын даргын 06 дугаар сарын 08-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар албан хаагчид дагаж мөрдөх “Ажил, үйлчилгээнд баримтлах заавар”-ыг баталлаа.

Түүнчлэн 06 дугаар сарын 08-ны өдөр “Төрийн хэмнэлтийн тухай” 02 дугаар албан даалгаврыг батлан, мөрдүүлж байна.

“Даталанд технологи” ХХК-тай байгуулах “Төсвийн хяналтын нэгдсэн платформ нэвтрүүлэх тухай” гэрээг бүртгэж, 06 дугаар сарын 09-ний өдөр батлав.

Монгол Улсын иргэний нэхэмжлэлтэй, Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын даргын итгэмжлэлийг 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1000 дугаар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хариу тайлбарыг холбогдох нотлох баримтын хамт 06 дугаар сарын 02-ны өдрийн 03/1006 дугаар албан бичгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тус тус хүргүүлсэн.

#### 2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин сууж байгаа гадаадын иргэний хувийн мэдээлэл, холбогдох нууцлалыг хангасан шинэлэг технологи бүхий программ ашиглахад шаардлагатай сервер, компьютер, оршин суух үнэмлэх хэвлэх төхөөрөмж зэрэг техник, хэрэгслийг нийлүүлэх талаар дэмжлэг хүсэх тухай 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/993 дугаар албан бичгээр Бүгд Найрамдах Турк Улсын ТИКА-гийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулалтын газарт хүсэлт хүргүүлээ.

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, эдийн засгийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд 2022 оны 4 дүгээр улиралд манай улсад хэрэгжүүлэх олон улсын чанартай арга хэмжээний төлөвлөгөөнд саналыг 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1022 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Болгар Улс дахь салбарын төлөөлөгчидтэй хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцох уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах тухай саналыг 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1039 дүгээр албан бичгээр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Монгол дахь салбарын хөтөлбөрийн газарт хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн албан айлчлалын үйл явц, үр дүнг 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1051 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт танилцуулав.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ИТЕС)-т хамрагдах нэр бүхий 25 албан хаагчийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай хүсэлтийг 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1054 дүгээр албан бичгээр тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдад хүргүүлсэн.

#### 2.3.2. Дотоод хяналт:

Байгууллагын даргын 2019 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах журам”-ыг 06 дугаар сарын 03-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, хуулийн санд байршууллаа.

Зуны улирал эхэлсэнтэй холбогдуулан амралт, чөлөөт цагаа өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй зөв боловсон өнгөрүүлж, аливаа осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх тухай “Зөвлөмж”-ийг 05 дугаар сарын 06-ны өдрийн 03/93 дугаар дотоод албан бичгээр болон дотоод үйл ажиллагааны



удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn)-ээр дамжуулан нийт албан хаагчдад хүргүүллээ.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Хууль тогтоомжийн хүрээнд 17 албан хаагчид 38 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 13 албан хаагчид 146 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлсөн.

Архивын 2020 оны баримтаас 802 хадгаламжийн нэгж дэх баримтыг данс, бүртгэлтэй тулган тооллого үйлдэж, хадгалах хугацаагаар нь нягтлан шалгалаа.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 7, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 16 буюу нийт 23 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 74 албан бичиг (хариутай 30)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд бүртгэлээр шилжүүлэн, нийт 81 албан бичгийг гадагш илгээсэн ба хяналтад 8 албан бичиг байна.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчаас төв байгууллагад 16 (иргэнээс 9, албан хаагчаас 7) өргөдөл, боомт, орон нутаг дахь нэгжид 30 (иргэнээс 12, албан хаагчаас 18) өргөдөл буюу нийт 46 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 42 өргөдлийг хугацаанд шийдвэрлэн, 4 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөлгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

“Eimmigration” системийн хөгжүүлэлтийн хүрээнд цагаачийн гарах-орох мэдэгдлийг хүлээж авах хэсгийг 06 дугаар сарын 10-ны өдөр ажиллагаанд оруулсан.

Цахим хуудасны хөгжүүлэлтээр визийн мэдээлэл хэсгийг засварлалаа.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

06 дугаар сарын байдлаар (өссөн дүнгээр) 4,918.1 сая төгрөгийн санхүүжилт авч 3,119.6 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд оны эхнээс 06 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болгон (өссөн дүнгээр) 406.7 сая төгрөгийн орлого, 1305124929 тоот валютын дансанд 111,043.54 ам.доллар буюу 341.1 сая төгрөг,

орон нутаг дахь нэгжүүд нийт 810.7 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлээд байна.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв “11-11”-өөс 05 дугаар сарын 03-аас 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд манай байгууллагад хандан шилжүүлсэн гомдол, хүсэлтийн агуулга болон шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийсэн тайланг 06 дугаар сарын 09-ний өдөр танилцуулав.

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 05 дугаар сарын статистик мэдээг 06 дугаар сарын 03-ны өдрийн 03/1025 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 05 дугаар сарын үйл ажиллагааны мэдээг мөн өдрийн 03/1026, 03/1027, 03/1028 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж ажилласан.

Байгууллагын 06 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд урьдчилсан хяналт шинжилгээ хийж, холбогдох санал дүгнэлт болон 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан 05 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 93.0 хувиар үнэлсэн тайлан боловсрууллаа.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээг 06 дугаар сарын 02-оос 10-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хэлбэрээр нийт 2 удаа хүргүүлсэн.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Хөвсгөл, Мөрөн олон улсын нисэх буудалд нислэг хүлээж авах үйл ажиллагааны бэлэн байдлыг хангасан тухай 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1069 дүгээр албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт, Говь-Алтай аймгийн Бургастай боомтын Зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборын барилгын зургийн саналыг 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1068 дугаар албан бичгээр Хайдродизайн прожект ХХК-д тус тус хүргүүллээ.

Орон нутаг дахь нэгжүүд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дотооддоо хууль, эрх зүйн болон Үндэсний бичиг, хятад хэлний чиглэлээр нийт 7 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн төрийн бусад байгууллагуудаас хууль эрх зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нийт 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 151 албан хаагч хамрагдсан.

Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас санаачлан зохион байгуулсан “Тохилог-Орчин” аяны хүрээнд Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн албан хаагчид албаны байрны гадна өнгө үзэмжийг сайжруулах засварын ажлыг 06 сарын 10-ны өдөр гүйцэтгэв.